

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Базар	Дугаар	L317
Оршин суугаа аймаг	Өвөрхангай	Оршин суугаа сум	Баян-Өндөр
Төрсөн газар	Баян-Өндөр сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Аман усны хийд	Сүм хийдийн дугаар	ӨХБР 068
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6 сарын 19	Ярилцлага авсан хүн	Жужа



Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сумын Аман усны хийд

Жужа: Аман усны хийдэд мөргөхөөр очсон уу, түүний талаар юу юу сонссон бэ, хэдэн лам байсан бэ?

Базар: Гучаад шахуу лам байсан байх. Нэг л дуган байсан.

Жужа: Суварга байсан уу?

Базар: Байсан.

Жужа: Тогтмол хуралтай байсан уу?

Базар: Тогтмол хуралтай байсан.

Жужа: Модон дуган байсан уу, тоосгон дуган байсан уу?

Базар: Модон дуган байсан. Арван хангал хураад найр хийдэг байсан юм гэнэ лээ. Би бас сайн мэдэхгүй.

Жужа: Одоогийн сумын төвд нэг шинэ дуган байна. Үүнийг сэргээхэд тэр Аман усны хийдийн лам нар байсан уу?

Базар: Ядамсүрэн гэж байсан. Цэнд гэж хүн байсан байх аа. Бадамтойн гэж хүн тахилч нь байсан.

Жужа: Тэр хийд хэзээ хаагдсан бэ?

Базар: Энэ эсэргүүний үед л хаагдсан. Арван хангал хураад найр хийдэг байсан юм.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Жужа: Хийдийн хамба лам хэн байсан бэ?

Базар: Сайн мэдэхгүй. Галсан гэлэн гэдэг хүн байсан.

Жужа: Тэр яг ямар нэртэй газар байсан бэ?

Базар: Аман ус гэдэг газар байсан.

Жужа: Тахидаг уул овоо байсан уу?

Базар: Байсан. Баян л юм даа.

Жужа: Аман усны энэ рашааныг нь яривал?

Базар: Нэг худагтай л юм.

Жужа: Энэ хийдийн талаар өөр мэддэг юм байгаа юу?

Базар: Өөр сайн мэдэхгүй.